



42 Page



43 Page



44 Page



45 Page



46 Page



47 Page

Содом ба Гоммора

-Sodom and Gomorrah-

Тайлбарлагч Эрт дээр үед Содом Гоморра хотод амьдардаг хүмүүс их гэм нүгэл үйлдэцгээжээ. Тэдний гэм асар их байсан тул Бурхан Абрахамд хандан тэр хотыг галд шатаан устгах төлөвлөгөө бэлдсэнээ хэлэв.

Бурхан "Би Содом ба Гоморраг устгах болно"

Тайлбарлагч Бурханы үгийг сонссон Абрахам тэнд амьдарч байгаа дүү Лотдоо санаа нь ихэд зовж, Бурханаас хичээнгүйлэн гуйжээ.

Абрахам "Бурхан минь, хэрэв Содом болон Гоморрад зөвт арван хүн байвал тэр арван хүний төлөө тэр газар нутгийг өршөөхгүй юу?"

Бурхан "Содом Гоморрад зөвт арван хүн байвал Би тэр газрыг өршөөнө."

Тайлбарлагч Гэвч тэнд арван зөвт хүн байсангүй. Бурхан тэр хотыг устгахаас өөр аргагүй боллоо. Гэсэн ч Лотын гэр бүлийг аврахаар болов. Бурханы илгээсэн хоёр тэнгэрэлч орой болох үед Лотын гэрт иржээ. Тэнгэрэлч гэж мэдээд тэднийг гэртээ оруулан хоол ундаар дайлжээ. Оройн хоол идсэний дараа Содомын эрчүүд Лотын гэрийн гадна ирж, зочидоо гарган явуул гэж шаардацгаажээ.

Лот "Хүмүүс ээ энэ хүмүүс манай гэрт ирсэн маш эрхэм зочид "

Тайлбарлагч Лот хүмүүсийг болиулах гэж оролдсон ч ямар ч нэмэр болсонгүй.

Тэнгэрэлч нар Лотыг гэрт нь оруулан хаалгыг хаав. Тэгээд хаалганы цаана байгаа хүмүүсийн нүдийг юу ч харахгүй болгоход тэд хаалгыг олж чадахгүй байв. Тэнгэрэлч нар Лотод хандан

Тэнгэр элч "Энэ хот гэм нүглээр дүүрсэн тул Бурхан энэ хотыг устгуулахаар биднийг энэ газар уруу явуулсан"

Тайлбарлагч Бурхан Содом хотын бүх хүмүүсийг устгах гэж байсан ч Абрахамыг санан Лотын гэр бүлийг амьд үлдээсэн нь энэ байлаа. Тэнгэрэлч Лотод хэлэв

Тэнгэр элч "Зугтаж байхдаа огтхон ч хойшоо эргэн харж болохгүй шүү. Тал газарт зогсолгүй уул өөд гүйгээрэй!"

Лот "За, ойлголоо. Та биднийг Зоар хүртэл аюулгүйгээр зугтаж чадахад туслаач"



48 Page



49 Page

Тайлбарлагч Лот тэнгэр элч нараас ийнхүү аминчлан гуйжээ.

Лот, Зоарт ирэхэд нар мандсан байжээ. Эзэн Бурхан Содом буюу Гоморра дээр хүхэр болон галыг тэнгэрээс буулгажээ. Маш том том хүхэрүүд бороо мэт тэнгэрээс орж, хоромхон зуур тэр газрын хүн, мал амьтан, орон байрыг шатааж орхив. Тэнгэрэлч нар зугтаж байхдаа хойшоо бүү эргэж хараарай гэж захьсан боловч Лотын эхнэрийн сэтгэл нь хорогдон эргэн хартал, тэр даруйдаа давсан хөшөө болчихжээ.